



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

147 /147/

2021.10.01

## ОЛОН УЛСЫН АХМАДЫН БАЯРЫН МЭНД ХҮРГЭЭ!

Түүхэнд энэ өдөр

1921 он:

Их даргын сургууль хичээлээ эхэлжээ.

1943 он

Д.Сүхбаатарын нэрэмжит бэлтгэл сургуулийг Д.Сүхбаатарын нэрэмжит Офицерын сургууль болгов.

### ГАВЬЯАТНЫ ӨМНӨ ТУГ НЬ БӨХИЙДӨГ ЮМ



мөрнийг гаталж, аагим халуун нар, шаагим хүйтэн бороон дундуур Жанчхүүгийн даваа, Жэхэ хот, Долоннуур хүртэл дайтаж явахад Байлдааны туг би бүх цэргийн дайчин манлайд, морьт дивизийн хүлгийн хийморьт, хуягт техникийн тэргүүн фронтод, нисэхэскадрилийн агаарын орон зайд давшилтад хүч нэмж, давхар бас зориг хайрлаж, ялалтад түрлэг өргөж, ядарсан олонд итгэл найдвар түгээж явлаа.

Бүхний тэргүүнд эрхэмсэг, ихэмсэг оршиж ирсэн, өнө мөнхөд мандан бадрах Байлдааны туг миний бие өнөөдөр харин гавьяатан танаа мэхийн ёсолж байна. Эх орныхоо төлөө халуун амиа хайрлаагүй, элгэн түмнийхээ төлөө бүлээн цусаа гамнаагүй, унасан газраа өмгөөлөн боссон, угаасан усаа хамгаалан тэмцсэн өчнөөн олон баатарлаг охид хөвгүүдийн дурсгалыг хүндэтгэж, эрх чөлөө, тусгаар тогтнолыг үр хойчдоо энэ биеэрээ өртөөлөн авч ирэхдээ дайн байлдааны талбарт исгэрэх сум, тэсрэх бөмбөгийг сөрж, эрэлхэг зоригтой байлдаж ирсэн ахмад дайчид та бүхэндээ гүнээ мэхийн хүндэтгэж байна. Та бүхний баатарлаг үйлсийг Монгол түмэн тэнгэрт нартай хамт мөнхөлж, газарт галтай цуг дархлан санаж сэрж явах учиртайг Аранзал улаан туг би ийнхүү тунхаглаж байна. Дайн дажингүй энх амгалан цагт амьдарна гэдэг юутай их завшаан болохыг, халдах дайсангүй эрх чөлөөтэй, тусгаар тогтнож оршино гэдэг ямар их зол тавилан гэдгийг, эв эвдрэхгүй, нэгэн цөм болж хүч оюунаа зангидаж хөгжинэ гэдэг хамгаас эрхэм чухгийг энэ цагийн Монгол түмэн, ирээдүй хойчийн үрсдээ энэ биеэрээ, эгэл бус амьдралаараа үлгэрлэн харуулж яваа эрхэм Ахмад дайчин, эгэлгүй гавьяатан танаа тэргүүн мэхийн хүндэтгэе.

Д.ГҮНЖИЛМАА

Энхийн тэнгэрт мөнхөд намирч, НҮБ-ын өмнө энхжин мандаж, эх орныхоо төрийн хойморт эрхэмсэг оршиж, дэлгэсэн тэрлэг шиг нутгийнхаа торгон хилийг сахин хамгаалж, дайчин эрсийнхээ жавхаа хийморийг хөгжөөж, даяар түмнийхээ уухайн түрлэгт Монгол төрийн далбаа оройн сүлд болон залардаг. Эх орны минь тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, эрх чөлөө хичнээн олон үрсийн халуун амь, бүлээн цусаар ирснийг сануулах мэт Байлдааны аранзал улаан туг цэргийн анги байгууллагын гэгээн хойморт дээдлэх ариун шүтээн, золбоо хийморийн бэлгэдэл болон оршдог.

Үндэсний эрх чөлөөг бэдэрсэн монгол түмэн минь Хиагтыг чөлөөлж, "шийдээд ирсэн гаминг ширмэн бөмбөгөөр сөнөөж", ардын хувьсгалаар тусгаар улсаа тунхаглаж байхад, дархан хилийг минь аймшиггүйгээр нэвтэрч,

дагшин ариун шороонд эзэрхгээр шунасан "дайсныг нэг ч алхам урагшуулж болохгүй, давшиж ирсэн бүхнийг устга" хэмээн сүүлчийн сумаа дуустал, эцсийн цусаа юүлтэл Байтаг богдын дайчин баатрууд тэмцэж байхад, Баянцагааны дээр хэдэн зуун онгоц эргэлдэж, агаарт ширүүн тулаан өрнөж, Халхын голын хөндийн байлдааны талбарт дэлбэрсэн сум, дарийн утаа, дүрэлзсэн гал там мэт харанхуйлж байхад, Чөлөөлөх дайнд оролцсон монгол дайчид орос ахан дүүс хамтдаа Цахарын элсэн цөлийг туулж, Хянганы өндөр уулсыг давж, олон арван гол



## "ТЭРБУМ МОД" ТАРИХ АЖЛЫГ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АЛБА ХААГЧИД ЭХЛҮҮЛЛЭЭ



### МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 298,536 +2650	ЭДГЭРСЭН 324,760 +6549	НАС БАРСАН 1204 +19
-----------------------------------	---------------------------	------------------------

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 5283 +90	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 187	ЭДГЭРСЭН 4994
-----------------------------	----------------------------	------------------

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ын Ерөнхий Ассемблейн хуралд үг хэлэхдээ Монгол улс 1 тэрбум мод тарих төлөвлөгөөтэй байгаа талаараа мэдэгдэж олон хүний талархлыг хүлээсэн.

Энэ хүрээнд "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн өрнүүлж, ойн салбарын мэргэжилтэн, эрдэмтэн, судлаачид, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулаад байгаа. Тус уулзалтаар "Мод тарьж ургуулах бол улс төржиж, намчирхаж, хийрхэх зүйл биш. Талцал, хуваагдлаа больж, байгаль орчноо хамгаалах, цөлжилт, газрын

доройтлын эсрэг үндэстнээрээ эв нэгдэлтэй, нэг зүгт харж зүтгэх цаг болсон. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, ялангуяа үндэсний томоохон компаниуд манлайлан оролцоно гэдэгт найдаж байгаа. Мөн Зэвсэгт хүчнийг татан оролцуулахаар төлөвлөж байгаа" хэмээн мэдэгдсэн. Үүний дагуу "Тэрбум мод" тарих ажлыг Зэвсэгт хүчний алба хаагчид эхлүүлээд байна. Тухайлбал, Зэвсэгт хүчний 350 дугаар ангийн алба хаагчид ангийнхаа байрлалд чацарганын 400 ширхэг мод тарилаа.

/үргэлжлэл нь арын нүүрт/

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 234,551,205
Эдгэрсэн Нийт: 211,349,941
Нас барсан Нийт: 4,797,146

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
10	0

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
29	15

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,848.00	2,850.00
EUR	3,33.0	3,345.0
CNY	440.3	442.0
RUB	38.50	39.70
JPY	25.19	25.70
KRW	2.36	2.45

### ЗУРХАЙ

2021.10.01 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 25/

НАМРЫН ДУНД УЛААГЧИН ТАХИА САРЫН ДӨРВӨН НОГООН ХАР МОРЬ ӨДӨР

Үс засуулбал:  
Нүд бүрэлзэн улцайна  
Наран ургах, шинжих:  
06.51-18.32

Барилдлага:  
Түлэх  
Шүтэн барилдлага:  
Өтлөх үхэхүй  
Суудал:  
Төмөр

Тухайн өдөр нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмт хэрэг илрүүлэх, гэм буруутныг шийтгэх, лусыг тахиж, андгай тангараг, гэрээ, хэлцлээ буцаахад сайн.

Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, сэтгэлд сэвтэй газар очих, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



цахим шууданд

# “ТЭРБУМ МОД” ТАРИХ АЖЛЫГ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АЛБА ХААГЧИД ЭХЛҮҮЛЛЭЭ



**Гүрүүч нь эхний нүүрт!**

Үүнээс гадна тус анги дан ганц ангийн байрлалаа ногоон төгөл болгох бус налайх дүүргийг ногоожуулах, моджуулахад дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд 10 дугаар сарын 4,5-ны өдрүүдэд тус дүүргийн Цэнгэлдэх хүрээлэнд 500 гаруй мод тарихаар төлөвлөжээ.

Үндэсний хэмжээнд яригдаж буй тус “тэрбум мод” хөдөлгөөний талаар иргэд, албан байгууллага санал санаачилгатай, идэвхтэй оролцож байгаа юм. Тухайлбал, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газар нэгдэж, ирэх 10 жилд 100 сая, “Эрдэнэс Таван толгой” хувьцаат компани тонн нүүрс тутамд нэг буюу 2030 он хүртэл 176 сая мод тарьж, ургуулахаар болжээ. Нийт газар нутгийн 76.9 хувь нь буюу 120 сая га талбай цөлжилтөд өртөж, газрын доройтолд орсон энэ үед Монгол Улсын Ерөнхийлөгч цаг үеэ олсон санаачилга гаргасан гэдгийг олон хүн онцолж байгаа юм. Энэ талаар албаны зарим хүн ийн ярьж байна.

**Ой судлалын ухааны доктор Н.Батхүү:** “Тэрбум мод” тарьж ургуулах зорилт хэрэгжих бүрэн боломжтой. Гол нь эрдэм шинжилгээ, судалгааны үр дүн, туршлага зэргийг харгалзаж, бодитой, үе шаттай төлөвлөгөө гаргах хэрэгтэй. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах бүтэц бий болгох

шаардлагатай. **Монголын жимс, жимсгэний үндэсний холбооны тэргүүн Д.Насанжаргал:** “Ойн зурвас, төглийг түшиглэн төрөл бүрийн жимс, жимсгэнэ тариалах хэрэгтэй. Товчхондоо нэг тэрбум модны 10 хувь нь жимс, жимсгэний мод, бут байгаасай гэж хүсэж байна. Хөрсөө сайжруулах бордоо үйлдвэрлэх, суулгацаа дотооддоо бэлтгэх, хүлэмжийн аж ахуйг дэмжих хэрэгтэй.

**МУИС-ийн багш Б.Оюунсанаа:** “Амаргүй зорилт. Гэхдээ үр дүнд хүрэх бүрэн боломжтой. Эхний элжинд мэргэжлийн боловсон хүчин, ажиллах хүч, тоног төхөөрөмж бүхий бүсчилсэн ойн анги байгуулж, түүнийг түшиглэн жижиг аж ахуйн нэгжүүд ажилладаг байвал зүгээр. Тэгэхээр удирдлага, зохион байгуулалтаар анхаарах хэрэгтэй.

**Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Н.Ганхуяг:** “Энэ хөдөлгөөнд 170 гаруй мянган малчин өрх идэвхтэй оролцох ёстой гэж бодож байна. Цөлжилт, бэлчээрийн доройтлоос болж нэг өрх гэхэд л жилд хоёр сая төгрөгийн орлогоо алддаг тооцоо бий”.

**Монголын их, дээд сургуулиудын консорциумын ерөнхийлөгч Т.Хэрүүга:** “Манай их, дээд сургуулийн багш, эрдэмтэн, судлаачид хамтраад хоёр дэд хөтөлбөр боловсруулж өгье. Ойн чиглэлээр суралцаж байгаа оюутнууддаа тэтгэлгээ түлхүү олгоё. 100 мянган ширхэг үрслэгээ бэлэн байна.

**“Цэцэрлэгжилт” компанийн захирал Ө.Магсаржав:** “Татварын бодлогоор дэмжих, хөнгөлөлттэй зээл

“Соёолж” компанийн ерөнхий захирал **Д.Даваасүрэн:** “Ойн тухай хуулийг шинэчилж, Хот, суурин газрын тухай хуулийг яаралтай батлах хэрэгтэй. Энэ хуулийн төсөлд дүүрэг бүр 5 га-гаас доошгүй талбайтай цэцэрлэгт хүрээлэнтэй байх, усалгаа үнэ төлбөргүй зэрэг олон чухал заалт байгаа. Мод үржүүлгийн газруудыг сайн дэмжих хэрэгтэй.

**“СЭЛЭНГЭ-2021” ТАКТИКИЙН ХЭЭРИЙН СУРГУУЛЬД АМЖИЛТАЙ ОРОЛЦОЖ БАЙНА**

**Зэвсэгт хүчний 337 дугаар анги**

Монгол Улс, ОХУ-ын Зэвсэгт хүчний хамтарсан “Сэлэнгэ-2021” тактикийн хээрийн сургуульд Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн захирагчийн нислэг эрхэлсэн нэгдүгээр орлогч-нисгэгч, хурандаа Н.Баясгалангаар ахлуулан нисгэгч, инженер, техникч, механикч, хангалт үйлчилгээний батальоны томилгоот бүрэлдэхүүн хээрийн сургуульд амжилттай оролцож байна.

Тус ангийн нисэх бүрэлдэхүүн Ми-24П 4 нэгж, Ми-8АМТШ 4 нэгж нисдэг тэрэгнүүд дээр штурман нисгэгчээр байлдааны курсийн дагуу хосоор нисэх, хосоор цохилт өгөх, хэсгээр цохилт өгөх, баруун пеленгээр нисэх дасгалуудыг ОХУ-ын Зүүн цэргийн тойргийн нисэх хүчний багш нисгэгч нарын удирдлагад хийж гүйцэтгэхээс гадна тус ангийн инженер, техникийн бүрэлдэхүүн нисдэг тэрэгнүүдэд инженер,

техникийн хангалтыг хийж, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлсэн ихээхэн ач холбогдолтой сургуулилт болж байгаа юм.

Мөн Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн болон ОХУ-ын хамтарсан хангалт үйлчилгээний батальоны томилгоот бүрэлдэхүүн

сургуулийн багш, эрдэмтэн, судлаачид хамтраад хоёр дэд хөтөлбөр боловсруулж өгье. Ойн чиглэлээр суралцаж байгаа оюутнууддаа тэтгэлгээ түлхүү олгоё. 100 мянган ширхэг үрслэгээ бэлэн байна.

Манай их, дээд сургуулийн багш, эрдэмтэн, судлаачид хамтраад хоёр дэд хөтөлбөр боловсруулж өгье. Ойн чиглэлээр суралцаж байгаа оюутнууддаа тэтгэлгээ түлхүү олгоё. 100 мянган ширхэг үрслэгээ бэлэн байна.

Манай их, дээд сургуулийн багш, эрдэмтэн, судлаачид хамтраад хоёр дэд хөтөлбөр боловсруулж өгье. Ойн чиглэлээр суралцаж байгаа оюутнууддаа тэтгэлгээ түлхүү олгоё. 100 мянган ширхэг үрслэгээ бэлэн байна.

Манай их, дээд сургуулийн багш, эрдэмтэн, судлаачид хамтраад хоёр дэд хөтөлбөр боловсруулж өгье. Ойн чиглэлээр суралцаж байгаа оюутнууддаа тэтгэлгээ түлхүү олгоё. 100 мянган ширхэг үрслэгээ бэлэн байна.



Манай их, дээд сургуулийн багш, эрдэмтэн, судлаачид хамтраад хоёр дэд хөтөлбөр боловсруулж өгье. Ойн чиглэлээр суралцаж байгаа оюутнууддаа тэтгэлгээ түлхүү олгоё. 100 мянган ширхэг үрслэгээ бэлэн байна.

Манай их, дээд сургуулийн багш, эрдэмтэн, судлаачид хамтраад хоёр дэд хөтөлбөр боловсруулж өгье. Ойн чиглэлээр суралцаж байгаа оюутнууддаа тэтгэлгээ түлхүү олгоё. 100 мянган ширхэг үрслэгээ бэлэн байна.

Манай их, дээд сургуулийн багш, эрдэмтэн, судлаачид хамтраад хоёр дэд хөтөлбөр боловсруулж өгье. Ойн чиглэлээр суралцаж байгаа оюутнууддаа тэтгэлгээ түлхүү олгоё. 100 мянган ширхэг үрслэгээ бэлэн байна.

Манай их, дээд сургуулийн багш, эрдэмтэн, судлаачид хамтраад хоёр дэд хөтөлбөр боловсруулж өгье. Ойн чиглэлээр суралцаж байгаа оюутнууддаа тэтгэлгээ түлхүү олгоё. 100 мянган ширхэг үрслэгээ бэлэн байна.

Манай их, дээд сургуулийн багш, эрдэмтэн, судлаачид хамтраад хоёр дэд хөтөлбөр боловсруулж өгье. Ойн чиглэлээр суралцаж байгаа оюутнууддаа тэтгэлгээ түлхүү олгоё. 100 мянган ширхэг үрслэгээ бэлэн байна.

Манай их, дээд сургуулийн багш, эрдэмтэн, судлаачид хамтраад хоёр дэд хөтөлбөр боловсруулж өгье. Ойн чиглэлээр суралцаж байгаа оюутнууддаа тэтгэлгээ түлхүү олгоё. 100 мянган ширхэг үрслэгээ бэлэн байна.

Манай их, дээд сургуулийн багш, эрдэмтэн, судлаачид хамтраад хоёр дэд хөтөлбөр боловсруулж өгье. Ойн чиглэлээр суралцаж байгаа оюутнууддаа тэтгэлгээ түлхүү олгоё. 100 мянган ширхэг үрслэгээ бэлэн байна.

# ДАЙНД ОРОЛЦСОН АХМАД ДАЙЧДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛНЭ



Жил бүрийн 10 дугаар сарын 1-ний өдрийг “Олон улсын ахмадын өдөр” болгон тэмдэглэж ирсэн билээ. Энэхүү тэмдэглэлт өдрийг тохиолдуулан 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайн болон Баруун хилийн тулгаралтад оролцсон ахмад дайчдад хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулж байгаа. ЗХЖШ-ын даргын

тушаалаар томилогдсон бүрэлдэхүүн “Эх орны дайчид” төрийн бус байгууллагатай хамтран өнгөрсөн долоо хоногт Улаанбаатар хотноо амьдарч буй дайнд оролцсон ахмад дайчдад гэрийнх нь гадна очиж, хүндэтгэл үзүүлэх ёслолын ажиллагааг зохион байгуулсан ба энэхүү ажил нь ахмад дайчдын сэтгэлд хүрсэн үйл ажиллагаа

болов.

Үүний үргэлжлэл болж эдгээр өдрүүдэд хөдөө, орон нутагт амьдарч байгаа дайнд оролцсон ахмад дайчдад хүндэтгэл үзүүлэх ёслолын ажиллагааг аймгуудын ЗДТГ-ын Цэргийн штаб, Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн ангиуд хамтран зохион байгуулах гэж байна.

Харин нийслэл хотод Баян-Өлгий аймгаас Улаанбаатар хотноо ирээд буй Б.Сейлхан, Хэнтий аймгаас ирсэн Т.Лувсансүх, Дархан-Уул аймгаас ирсэн ахмад дайчин Б.Ядамсүрэн, Дундговь аймгаас ирсэн Н.Пүрэвжалба нарт ЗХЖШ, Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим, ЦДБЭЧ, Монгол цэргийн музей, Зэвсэгт хүчний 032 дугаар ангиас томилогдсон цөөн тооны бүрэлдэхүүн хүндэтгэл үзүүлж байна.

**Хурандаа Б.ОТГОНБАЯР**

# АНГИ СУРТАЛЧЛАХ ӨДӨРЛӨГ БОЛЛО



**Зэвсэгт хүчний 337 дугаар анги** Монгол Улс, ОХУ-ын Зэвсэгт хүчний хамтарсан “Сэлэнгэ-2021” тактикийн хээрийн сургуульд оролцож буй Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн нисгэгч, инженер, техникч, механикч, хангалт үйлчилгээний батальоны бүрэлдэхүүн анги сурталчлах өдөрлөгийг 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр ангийнхаа нисэх буудалд зохион байгууллаа.

Анги сурталчлах өдөрлөгийг ангийн захирагч, хурандаа Г.Бат-Орших нээж

хэлсэн үгэндээ, “Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Сэлэнгэ” тактикийн хээрийн сургуульд манай анги 2014 оноос хойш оролцож байна. Ах дүүгийн найрамдалт ОХУ-ын Зүүн цэргийн тойргийн Нисэх хүчний инженер, техникийн бүрэлдэхүүнд хээрийн сургуульд амжилттай оролцохыг хүсэж, манай ангийн нисэх бүрэлдэхүүний нислэгийн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж байгаад талархаж байна” гэсэн юм. Мөн захирагчийн

нислэг эрхэлсэн нэгдүгээр орлогч-нисгэгч, хурандаа Н.Баясгалан, Нисэх хүчний 11 дүгээр армийн томилгоот бүрэлдэхүүний ахлах нисгэгч, дэд хурандаа Ю.М.Валичко нар сургуульд оролцож буй бүрэлдэхүүнд ая дууны мэндчилгээ дэвшүүлж хоёр улсын нөхөрсөг, найрсаг харилцааг илэрхийлсэн юм.

Өдөрлөгийн хүрээнд Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн бие бүрэлдэхүүн хүндэтгэлийн зоогоор угтаж, урлагийн хэсэгчилсэн тоглолтыг толилууллаа.

# АЖЛЫН БАЙРНЫ АНХАН ШАТНЫ СУРГАЛТ ЯВАГДЛАА



**Зэвсэгт хүчний 337 дугаар анги**д ҮБХИС-ийг төгсөж тус ангид томилогдсон цэргийн алба хаагчидтай ангийн 2020-2021 оны цэргийн сургалт бэлтгэлийн

төлөвлөгөөний дагуу ажлын байрны анхан шатны сургалтыг 2021 оны 9 дүгээр сарын 13-24-ний өдрүүдэд зохион байгуулан явууллаа. Сургалтаар шинээр

томилогдон ирсэн цэргийн алба хаагчдад Монгол Улсын Батлан хамгаалах салбарын багц хуулиуд, цэргийн нийтлэг дүрмүүдийг судлуулж, цэргийн алба болон ангийн өдөр тутмын үйл ажиллагааг танилцуулан, байлдааны болон тайван цагийн цэргийн удирдлагыг хэрэгжүүлэх арга зүйг эзэмшүүлэх талаар батлагдсан хичээлийн хөтөлбөр, конспектийн дагуу сургалт явагдсан юм.

Сургалтын эхэнд түвшин тогтоох шалгалт авч, бие бүрэлдэхүүний түвшинг тогтоон сургалтын төгсгөлд төгсөлтийн шалгалт авч дүгнэлээ. Мөн ангийн удирдлагаас шинэ төгсөгч нарт ажлын амжилт хүсэж, үүрэг даалгавар өгч, шинэ ажилд нь амжилт хүслээ.

**Хошууч Т.ТАМИР**